

БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Р. БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ,ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ.**

НЭГ. ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ БОЛСОН ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА.

1.1. ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ.

“Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаанд хориглох зүйл” гэсэн 40 дүгээр зүйлийн “Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно.” гэсэн 40.1 дэх заалтад “40.1.2. өөр шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч байх. Тайлбар: -Энэ заалтыг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөнө.” гэж заажээ.

Гэтэл “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль”-ийн “Төлөөлөгчид нэр дэвшүүлэх эрх” гэсэн 6 дугаар зүйлд “6.5.Сум, дүүргийн Хурлын Төлөөлөгчид нэр дэвшигч нь аймаг, нийслэлийн Хурлын Төлөөлөгчид зэрэг нэр дэвшиж болно.” гэж заажээ.

Дурдаж буй хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тул сумын болон аймгийн ИТХ-ын Төлөөлөгчөөр давхар ажиллаж болохгүй талаар “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн заалтыг “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль”-д нийцүүлэх нь зүйтэй байна.

1.2. ПРАКТИК ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА.

“Иргэний хууль”-ийн “Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ.” гэсэн 3.3 дахь заалтын дагуу энэ асуудлыг шийдвэрлэхэд боломжгүй мэт ойлгогдож байна. Учир нь энэ хоёр хууль нь нэг асуудлыг биш тус тусын буюу нэг нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үйл ажиллагааг нөгөө нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааг зохицуулж байгаа.

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль”-ийг баримтлан Сумын болон Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчөөр давхар нэр дэвшиж сонгогдсон нөхцөлд Төлөөлөгчийн бүрэн эрхээ

хүлээн зөвшөөрүүлж Хурлын үйл ажиллагаанд оролцох боломжгүй болж маргаан гарч болзошгүй байна.

“Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн “40.1.2. өөр шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч байх. Тайлбар: -Энэ заалтыг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөнө.” гэж заасныг дагаж мөрдөснөөр давхар сонгогдсон ИТХ-ын төлөөлөгч нь аль нэг хурлын төлөөлөгчөөр ажиллахаас татгалзах шаардлагатай болж байгаа тул олон тооны нөхөн болон дахин сонгууль зарлан явуулах бодит эрсдэл үүсэж байна.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА, ХАМРАХ ХҮРЭЭ.

“Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн төслийг 2 зүйлтэй байхаар боловсруулна.

1 дүгээр зүйлээр “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн “40.1.2. өөр шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч байх. Тайлбар: -Энэ заалтыг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөнө.” Заалтыг, хүчингүй болгохоор тусгана.

2 дугаар зүйлээр хуулийн төслийн дагаж мөрдөх хугацааг тусгана.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНЫ ДАРАА ҮҮСЭЖ БОЛОХ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, ХУУЛЬ ЗҮЙН ҮР ДАГАВАР

“Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл батлагдсанаар хууль тогтоомжийн зөрчил арилж, давхар сонгогдсон ИТХ-ын төлөөлөгчид бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангагдана.

ДӨРӨВ. ХУУЛИЙН ТӨСӨЛ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ, МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ БОЛОН БУСАД ХУУЛЬТАЙ, ХЭРХЭН УЯЛДАХ, ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БОЛОВСРУУЛАХ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТАЛААР.

“Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай нийцэж байгаа бөгөөд уг хуулийн төсөлтэй хамт боловсруулах хууль тогтоомжийн төсөл байхгүй болно.